



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 149

Дархан сум

Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа  
хамтран өмчилсөн газрыг гэр бүлийн  
нэг гишүүнд шилжүүлэх тухай


Монгол улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай тухай" хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 "Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалтууд, "Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай" хуулийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран газар өмчилсөн иргэдийн эрх шилжүүлэх гэрээ, хэлцлийг харгалзан нэгдүгээр хавсралтанд дурьдсан 1 иргэний газрыг үнэ төлбөргүй шилжүүлэн өмчлүүлсүгэй.

2. Гэр бүлийн нэг гишүүний өмчилж авсан газарт энэхүү захирамжийг үндэслэн газрын кадастр хийх, газар өмчлөгчид хүлээлгэн өгөх, хилийн заагийг газар дээр нь тэмдэгжүүлэх, улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг сумын газрын даамал (Г.Ганболд)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Дархан сумын Засаг даргын 2005 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 56 тоот захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Газраа шилжүүлсэн иргэдэд хууль тогтоомжид заасны дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Г.БАТБОЛД

